



УЛААНБААТАР ХОТЫН  
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Шуурхай ажиллагааны танхимыг  
цэцэгжүүлэх тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын шуурхай ажиллагааны танхимын эрүүл ахуйн шаардлагыг хангуулж дэлгэц болон төхөөрөмжийн хорыг саармагжуулах, ажилчдын эрүүл таатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шуурхай ажиллагааны танхимыг цэцэгжүүлэх ажлыг Ерөнхий диспетчер /Г.Ганзориг/-т үүрэг болгосугай.

2. Шуурхай ажиллагааны танхимыг цэцэгжүүлэхэд шаардагдах 208350 /хоёр зуун найман мянга гурван зуун тавь/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР